



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/282/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит
ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан
Утас: 99099119 Цахим хаяг: info@ghtaudit.mn

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-14
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14-15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт...	16-18
4. Аудитын тайлан	19-22
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	19-20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20-21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21-22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. Аудитын илрүүлэлт	23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 02. 25 № 01/170
танай _____ -ны № _____ -т

БАГАНУУР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА
Р.ӨНӨРЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын бүтэц өөрчлөгдөж Нийгмийн даатгалын газар болж төсвийн санхүүжилт өмнөх оноос 184.4 сая төгрөгөөр буюу 28.5 хувиар нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.0 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

02073870

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,557,761.50	29,411,847.50
35	БАРАА МАТЕРИАЛ	34,557,761.50	29,411,847.50
35400	Хангамжийн материал	34,557,761.50	29,411,847.50
35410	Бичиг хэргийн материал	6,600,180.00	5,622,150.00
35420	Аж ахуйн материал	25,447,094.50	17,359,844.50
35430	Сэлбэг хэрэгсэл	678,020.00	4,946,120.00
35440	Түлш, шатах тослох материал	-	208,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,832,467.00	1,275,733.00
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	602,839,761.92	595,969,355.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	602,839,761.92	595,969,355.35
39200	Биет хөрөнгө	572,139,761.92	565,269,355.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	569,475,555.00	569,475,555.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,590,009.81)	(72,231,956.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,235,000.00	8,235,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,058,750.00)	(4,460,625.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	62,666,242.98	90,001,451.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,485,661.94)	(49,966,501.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,156,100.00	63,257,583.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,258,714.31)	(39,041,152.00)
39300	Биет бус хөрөнгө	30,700,000.00	30,700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,700,000.00	30,700,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	637,397,523.42	625,381,202.85

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	637,397,523.42	625,381,202.85
51	Засгийн газрын хувь оролцоо	637,397,523.42	625,381,202.85
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	336,114,363.39	336,114,363.39
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	336,114,363.39	336,114,363.39
51200	Хуримтлагдсан үр дүн	278,878,308.37	266,861,987.80
51210	Өмнөх үеийн үр дүн	278,878,308.37	278,878,308.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	(12,016,320.57)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,404,851.66	22,404,851.66
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	637,397,523.42	625,381,202.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	623,509,611.60	852,478,083.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,359,711.60	20,585,783.14
120	Нийтлэг татварын бус орлого	3,359,711.60	20,585,783.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,359,711.60	20,585,783.14
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,359,711.60	19,662,583.14
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	923,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	620,149,900.00	831,892,300.00
1310	Төсвийн захирагчдаас	507,800.00	831,892,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	831,892,300.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	507,800.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	619,642,100.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	619,642,100.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	646,512,438.83	855,293,553.71

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,512,438.83	855,293,553.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,267,270.92	767,316,213.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,973,611.25	597,083,892.50
210101	Үндсэн цалин	235,047,561.31	296,203,296.90
210102	Нэмэгдэл	64,077,831.99	119,492,957.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,992,633.27	97,909,400.78
210104	Урамшуулал	54,855,584.68	83,478,236.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,631,347.39	75,745,719.01
210201	Тэтгэврийн даатгал	34,839,417.37	50,947,136.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,217,155.01	6,304,096.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,346,789.18	3,321,894.50
210204	Ажилгүйдлийн даатгал	854,854.18	3,250,070.58
210205	Эрүүл мэндийн даатгал	8,373,131.65	11,922,520.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,094,382.65	22,311,487.20
210301	Гэрэл, цахилгаан	3,615,826.22	4,417,858.82
210302	Түлш, халаалт	15,175,996.43	16,397,608.38
210303	Цэвэр, бохир ус	1,302,560.00	1,496,020.00
	Хангамж, бараа материалын зардал	15,228,260.80	16,433,478.79
210401	Бичиг хэрэг	5,748,720.00	6,787,060.00
210402	Тээвэр, шатахуун	1,633,100.00	2,594,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,894,906.80	3,448,038.79
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	503,400.00	804,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,149,750.00	2,800,380.00

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210408	Бараа материал акталсны зардал	298,384.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,455,000.00	1,524,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00	-
210604	Урсгал засвар	53,255,000.00	1,524,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,784,000.00	1,112,000.00
210702	Дотоод албан томилолт	3,784,000.00	1,112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,314,328.00	13,251,176.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,063,500.00	5,335,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,200,000.00	6,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	569,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,752.00	91,752.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286,000.00	-
210807	Газрын төлбөр	92,100.00	92,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	171,532.00	17,390.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	409,444.00	645,934.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,786,340.83	39,854,059.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,368,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	350,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,418,340.83	39,504,059.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,245,167.91	87,977,340.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,185,411.00	42,111,498.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,185,411.00	5,783,850.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	36,327,648.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	45,865,842.50

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,865,842.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,059,756.91	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,059,756.91	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	(23,002,827.23)	(2,815,470.57)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	9,200,850.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	9,200,850.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(23,002,827.23)	(12,016,320.57)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	647,149,236.02	831,892,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,507,136.02	-
120	Нийтлэг татварын бус орлого	27,507,136.02	-
120009	Бусад орлого	27,507,136.02	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	619,642,100.00	831,892,300.00
1310	Төсвийн захирагчдаас	-	831,892,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	831,892,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	619,642,100.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	619,642,100.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	646,393,228.77	818,921,230.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,393,228.77	818,921,230.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,884,668.11	730,943,889.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,973,611.25	597,083,892.50
210101	Үндсэн цалин	235,047,561.31	296,203,296.90
210102	Нэмэгдэл	64,077,831.99	119,492,957.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,992,633.27	97,909,400.78

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210104	Урамшуулал	54,855,584.68	83,478,236.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,611,947.39	75,745,719.01
210201	Тэтгэврийн даатгал	34,829,517.37	50,947,136.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,217,155.01	6,304,096.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,340,789.18	3,321,894.50
210204	Ажилгүйдлийн даатгал	851,354.18	3,250,070.58
210205	Эрүүл мэндийн даатгал	8,373,131.65	11,922,520.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,094,382.65	22,311,487.20
210301	Гэрэл, цахилгаан	3,615,826.22	4,417,858.82
210302	Түлш, халаалт	15,175,996.43	16,397,608.38
210303	Цэвэр, бохир ус	1,302,560.00	1,496,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,735,706.80	15,553,048.79
210401	Бичиг хэрэг	9,498,100.00	5,809,030.00
210402	Тээвэр, шатахуун	1,633,100.00	2,802,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,894,906.80	3,448,038.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	503,400.00	804,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,206,200.00	2,689,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,455,000.00	6,182,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00	4,658,100.00
210604	Урсгал засвар	53,255,000.00	1,524,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,784,000.00	1,112,000.00
210702	Дотоод албан томилолт	3,784,000.00	1,112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,354,884.00	12,605,242.00

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,513,500.00	5,335,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,200,000.00	6,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	569,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,752.00	91,752.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286,000.00	-
210807	Газрын төлбөр	92,100.00	92,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	171,532.00	17,390.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,875,136.02	350,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,875,136.02	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,508,560.66	87,977,340.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,185,411.00	42,111,498.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,185,411.00	5,783,850.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	36,327,648.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	45,865,842.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,865,842.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,323,149.66	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,323,149.66	-
3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	756,007.25	12,971,070.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	-	12,971,070.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	12,971,070.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	12,971,070.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	12,971,070.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(12,971,070.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	756,007.25	-

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	301,881,135.60	660,400,350.65
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	301,881,135.60	660,400,350.65
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(23,002,827.23)	(23,002,827.23)
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	278,878,308.37	637,397,523.42
5	2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	278,878,308.37	637,397,523.42
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	278,878,308.37	637,397,523.42
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,016,320.57)	(12,016,320.57)
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	266,861,987.80	625,381,202.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

1	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	831,892,300.00	786,026,457.50	45,865,842.50	94.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	831,892,300.00	786,026,457.50	45,865,842.50	94.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	787,884,300.00	743,914,959.50	43,969,340.50	94.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613,292,100.00	597,083,892.50	16,208,207.50	97.4
210101	Үндсэн цалин	308,072,300.00	296,203,296.90	11,869,003.10	96.1
210102	Нэмэгдэл	116,149,900.00	119,492,957.84	(3,343,057.84)	102.9

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,812,000.00	97,909,400.78	(97,400.78)	100.1
210104	Урамшуулал	91,257,900.00	83,478,236.98	7,779,663.02	91.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,431,500.00	75,745,719.01	685,780.99	99.1
210201	Тэтгэврийн даатгал	51,899,800.00	50,947,136.54	952,663.46	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,132,900.00	6,304,096.55	(171,196.55)	102.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,066,500.00	3,321,894.50	(255,394.50)	108.3
210204	Ажилгүйдлийн даатгал	3,066,500.00	3,250,070.58	(183,570.58)	106.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,265,800.00	11,922,520.84	343,279.16	97.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,834,900.00	22,311,487.20	17,523,412.80	56.0
210301	Гэрэл, цахилгаан	6,644,900.00	4,417,858.82	2,227,041.18	66.5
210302	Түлш, халаалт	31,236,000.00	16,397,608.38	14,838,391.62	52.5
210303	Цэвэр, бохир ус	1,954,000.00	1,496,020.00	457,980.00	76.6
2104	Хангамж, бараа материалын зардал	17,562,100.00	15,553,048.79	2,009,051.21	88.6
210401	Бичиг хэрэг	6,456,000.00	5,809,030.00	646,970.00	90.0
210402	Тээвэр, шатахуун	3,114,000.00	2,802,000.00	312,000.00	90.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,942,500.00	3,448,038.79	494,461.21	87.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	808,000.00	804,000.00	4,000.00	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,241,600.00	2,689,980.00	551,620.00	83.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,479,200.00	19,153,570.00	1,325,630.00	93.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,479,200.00	17,629,170.00	850,030.00	95.4
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,524,400.00	475,600.00	76.2
2107	Томилолт, зочны зардал	2,200,000.00	1,112,000.00	1,088,000.00	50.5

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	1,112,000.00	1,088,000.00	50.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,560,600.00	12,605,242.00	4,955,358.00	71.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,552,400.00	5,335,000.00	217,400.00	96.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,916,400.00	6,500,000.00	4,416,400.00	59.5
210803	Даатгалын үйлчилгээ	569,000.00	569,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,100.00	91,752.00	55,348.00	62.4
210807	Газрын төлбөр	96,100.00	92,100.00	4,000.00	95.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	279,600.00	17,390.00	262,210.00	6.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	523,900.00	350,000.00	173,900.00	66.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,500.00	-	82,500.00	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	441,400.00	350,000.00	91,400.00	79.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,008,000.00	42,111,498.00	1,896,502.00	95.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,008,000.00	42,111,498.00	1,896,502.00	95.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,679,300.00	5,783,850.00	1,895,450.00	75.3
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,328,700.00	36,327,648.00	1,052.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	831,892,300.00	786,026,457.50	45,865,842.50	94.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	831,892,300.00	786,026,457.50	45,865,842.50	94.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	831,892,300.00	786,026,457.50	45,865,842.50	94.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	41.00	41.00	-	100.0

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	21.00	(1.00)	105.0
620001	Удирдах ажилтан	4.00	1.00	3.00	25.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	18.00	(4.00)	128.6
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20.00	19.00	1.00	95.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14.00	13.00	1.00	92.9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар 2024 оныг "Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх" зорилгыг дэвшүүлэн ажилласан байна. Дээрх зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;
- Тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох;
- Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалын үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэх.

НДЕГ-ын даргын 2024 оны А/52, А/109 дүгээр тушаал болон Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны А/12 дугаар тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна. Үүнд удирдлага нэг, захиргаа, хяналтын хэлтэс 9, санхүү бүртгэл, орлогын хэлтэс 5, тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс 5, нийт 20 орон тоотой байхаар баталсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчилсэн найруулгыг баталж 2024 оноос мөж эхэлсэн;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ харж буй эцэг, эхүүдийг сайн дурын даатгалд хамруулах зорилгоор НДШ-ийн 50%-ийг төрөөс хариуцах, мөн малчдын НДШ-ийн 50%-ийг төрөөс хариуцах болсон;
- Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ систем нэвтрүүлсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай";
- ЗГ-ын 2024 оны 2 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай";
- МУ-ын 2024 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /2024 оны 8 дугаар сарын 30/

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

НДЕГ-ын даргын 2022 оны А/65 дугаар тушаалаар харьяа байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,016.3 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	34,557.7	29,411.8	- 5,145.9
Үндсэн хөрөнгө	602,839.7	595,969.3	- 6,870.4
Нийт хөрөнгө	637,397.5	625,381.2	- 12,016.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	637,397.5	625,381.2	- 12,016.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	637,397.5	625,381.2	- 12,016.3

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 29,411.8 мянган төгрөг болж 5,145.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх аудитын зөвлөмжийн дагуу 9,200.8 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна. Бараа материалын нийт үлдэгдлийн 78.0 хувийг ажилтан албан хаагчдад ашиглуулж байгаа бичиг хэргийн болон аж ахуйн материал (ус буцалгагч, тамга тэмдэг, тооны машин, цаас зүсэгч, уртасгагч, сүлжээний хэрэгсэл г.м) эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 595,969.3 мянган төгрөг болж 6,870.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд ТӨБЗГ-ын шийдвэрээр 9,030.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөггүй тоног төхөөрөмж, тавилга эд хогшлийг данснаас хасч шинээр үнэ тогтоон 3,521.7 мянган төгрөгөөр буцаан орлого авахад үүссэн зөрүүгээс голлон шалтгаалсан байна. Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 625,381.2 мянган төгрөг болж, 12,016.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 947,051.5 мянган төгрөг, нийт зарлагыг 947,051.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 215,565.3 мянган төгрөгөөр бууруулж, 731,486.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг Сангийн яамнаас бууруулж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2024 оны 4, 7, 9, 11, 12 саруудад нэмж 5 удаа тодотгосон ба нийт 100,406.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд зориулж 831,892.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 831,892.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны зардалд 786,026.4 мянган төгрөгийг зарцуулан, зарцуулагдаагүй үлдэгдэл 45,865.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 786,026.4 мянган төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 685.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17,523.4 мянган төгрөгөөр, бусад зардлыг 9,551.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, зориулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
Д/д	Хөтөлбөр	Зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нийгмийн даатгал	Үндсэн үйл ажиллагааны зардал	738,287.4	694,318.1	43,969.3	94.0
2	Нийгмийн даатгал	Харуул, хамгаалалтын зардал	3,960.0	3,960.0	-	100.0
3	Нийгмийн даатгал	Хуульд заасан үндэслэлээр алба	1,275.3	1,275.3	-	100
4	Нийгмийн даатгал	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	36,328.7	36327.6	1.1	99.9
5	Нийгмийн даатгал	Бусад тусламж, дэмжлэг	6,404.0	4,508.5	1,895.5	70.4

**Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

6	Нийгмийн даатгал	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	8,910.0	8,910.0	-	100
7	Нийгмийн даатгал	Өмгөөлөл, хуулийн зөвлөгөө хөлс	392.4	392.4	-	100
8	Нийгмийн даатгал	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	36,334.5	36,334.5	-	100
		Нийт дүн	831,892.3	786,026.4	45,865.9	94.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь тайлант оны төсвөөс 12,971.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө, 18,231.2 мянган төгрөгөөр бараа материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нягтлан бодох бүртгэл, шилэн дансны ил тод байдлыг сайжруулах, худалдан авах ажиллагааны хууль журмыг хэрэгжүүлэхээр өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт Хөхийн Тэнцвэр Аудит ХХК-ийн аудитор Ш.Нарантуяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Д.Хишгээ, захирал Д.Баатарсайхан, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үндсэн үйл ажиллагааны нийт зардлын 738,287.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,382.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага байгууллагын орон тоог нэмэгдүүлэхгүй байх, тогтмол зардал, бичиг хэрэг, томилолт, шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулахгүй байх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг судалгаанаас харахад дэд дарга, орлогч дарга, зөвлөхийн орон тоо бий болгоогүй, дуудлагын автомашин ашигладаггүй, төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас, бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй, бараа материал их хэмжээгээр нөөцлөөгүй, ус дулааны хэрэглээг тоолуураар тооцдог, тайлант онд тоолуурыг баталгаажуулсан, албан томилолтын зардлыг давхардуулан олгоогүй байна.

Төсвийн шууд захирагч нь тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт хүргүүлээгүй, албан хэрэгцээнд ашиглах зориулалттай 31,202.3 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдаж аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-т зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Захиалгын хүсэлтийг илгээж, ерөнхий гэрээнд заасан бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 348,993.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь 2024 онд нийт 1,065,568.5 мянган төгрөгийн 211 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 317,790.9 мянган төгрөгийн 11 мэдээллийг тухай бүрт ил тод байршуулаагүй байна. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,500.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, 302,252.5 мянган төгрөгийн орлогын 8 гүйлгээ, худалдан авалтын 9,038.4 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.4-т *"Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"*, 6.4.5-т *"Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"* долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn сайтад ил тодоор байршуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.3-д *"Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ"* гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг төлөвлөн батлах, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгадагч байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, цалин, өр төлбөр, бараа материалын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгадагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, 1,262.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,557.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргүүлснийг шалгахад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул жилийн эцсийн аудитын тайланд зөрчлөөр оруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 635,151.0 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснөөс 9,194.6 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 625,456.4 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	500.0	1	500.0	100.0
Албан шаардлага	1	625,456.4	1	0	0
Зөвлөмж	2	9,194.6	2	9,194.6	100.0
Нийт дүн	4	635,151.0	4	9,694.6	66.6

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжээгүй шалтгаан нь шилэн дансны мэдээлэлд удирдлагаас тавих хяналт сул, тус газрын ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч нар тайлант онд солигдсон зэргээс шалтгаалсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар тодорхойлсон цахим дэлгүүрээс хөрөнгө, бараа материал худалдан авах ажиллагаанд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,197.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6,197.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн 6,197.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,185.7 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1.1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, хүүхдийн бэлэг, өдөрлөгийн зардал зэрэгт худалдан авсан 3,388.0 мянган төгрөгийн бараа материалыг эд хариуцагчийн тайланд бүртгэхгүйгээр, шууд зардлаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: Үүнд 14.4.1. аж ахуйн бүх ажил, гүйлгээ, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, ... илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд гарсан аж ахуйн бүх ажил, гүйлгээг бараа материалын тайланд орлого, зарлагаар бүртгэн тайлагнаж байх;

5.1.2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: И-баримтаарх худалдан авалтыг байгууллага тус бүрээр тулгаж үзэхэд харилцагч 4 байгууллагын 2,809.1 мянган төгрөгийн нэхэмжлэхийг цахим системд илүү оруулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацааны эцэст татварын цахим системд илүү нэхэмжлэх шивсэн байгууллагуудын төлбөр тооцоог хянан баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөр ийн акт		Албан шаард лага		Зөвлөмж		Хариуцла га тооцуулах албан шаардлаг а		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаа лтны тоо	Тоо	Дүн
Бараа материалт ай холбоотой	1	3,388.0					1	3,388.0				
Ибаримтт ай холбоотой	1	2,809.1					1	2,809.1				
Дүн	2	6,197.1					2	6,197.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудаст ажил үйлчилгээг мэдээлээгүй	1	317,790.9			1	317,790.9
Дүн	1	317,790.9			1	317,790.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг системд ил тодоор байршуулаагүй	1	0			1	0
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	31,202.3			1	31,202.3
Дүн	2	31,202.3			2	31,202.3
Нийт дүн	3	348,993.2			3	348,993.2

Утас: +976 70007734

Факс: +976 70007734

Цахим шуудан: ub@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Нийслэлийн өмчийн нэгдүгээр байр,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар
дүүрэг Улаанбаатар-15160, Монгол Улс